



## ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:

### Захиалагч:

YAG-ын САГ-ын захирал  
бөгөөд тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663

Аудитын менежер  
Г.Гүнжидмаа  
Утас: 261885

Аудитор  
Ц.Хосжаргал  
Утас: 260512

Монгол Улсын Үндэсний  
Аудитын Газар  
Засгийн газрын IV байр, Бага  
тойруу-6, Улаанбаатар-46, Монгол  
улс  
Вэб хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

### Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч:

#### “Номгон Аудит” ХХК

Гүйцэтгэх захирал  
Г.Саранчимэг  
Гар утас: 89891034  
Цахим хаяг:  
[nomgonaudit@yahoo.com](mailto:nomgonaudit@yahoo.com)

Аудитор  
О.Мандах  
Б.Давгабазар

Хаяг: Чингэлтэй дүүрэг, Жуулчны  
гудамж, Тайваны төв, 409 тоот  
Утас: 70100023

### Аудитын тайлан

Хавсралт 1. Агуулга

Хавсралт 2. Аудитын гэрчилгээ

Хавсралт 3. Менежментийн захидал

Хавсралт 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ .....	0
2	Аудитын тайлан .....	1
2.1	Оршил .....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	3
2.5	Дотоод хяналт .....	4
2.6	Сангийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар .....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	5
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	5
2.9.1	Хууль эрх зүйн орчны талаар .....	5
2.9.2	Эрсдэлийн сангийн талаар .....	5
2.9.3	Нөөц сангийн хөрөнгийн талаар .....	6
2.9.4	Үйл ажиллагааны зардлын төсвийн төлөвлөлтийн талаар .....	6
2.9.5	Мөнгөн хөрөнгийн талаар .....	6
2.9.6	Санхүүгийн тайлагналын талаар .....	7
2.9.7	Биет бус хөрөнгийн талаар .....	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	8
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: .....	8
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Менежментийн захидал .....	10
3.1	Үйл ажиллагааны зардлын төсвийн төлөвлөлтийн талаар .....	11
3.2	Мөнгөн хөрөнгийн талаар .....	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	15
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ П.ЧАНДМАНЬ  
ТАНАА**

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Зээлийн батлан даалтын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зээлийн батлан даалтын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Зээлийн батлан даалтын сангийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу, тайлант хугацааны Санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.



Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 ОРШИЛ

Зээлийн батлан даалтын сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал П. Чандмань танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Зээлийн батлан даалтын сангийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйл ажиллагааны зардлыг журмын дагуу төлөвлөх, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5 Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2018/134/СТА-ТӨҮГ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Зээлийн батлан даалтын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Зээлийн батлан даалтын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга, програм хангамжийн дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Зээлийн батлан даалтын сангийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 10-ны өдөр “Номгон Аудит” ХХК-д ирүүлсэн байна.



“Номгон Аудит” ХХК нь аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-нд Зээлийн батлан даалтын сангийн удирдлагад гардуулна.

### 2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зорилго нь “Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сангийн үйл ажиллагааг оновчтой, үр ашигтай явуулах” гэж тодорхойлсон байна. Зээлийн батлан даалтын сан нь 2017 онд дор дурдсан чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд:

- Төв орон нутгийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хуульд заасны дагуу зээлийн батлан даалт гаргах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах,
- Батлан даалттай зээлд хяналт тавих, өр барагдуулах үйл ажиллагааны чанарыг сайжруулах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх,
- Сангийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль, дүрэм журмын хэрэгжилтийг сайжруулах,
- Удирдлагын мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн чанар, давтамжийг сайжруулах,
- Байгууллагын хүний нөөцийн чадамжийг дээшлүүлэх, санхүүгийн нөөцийн чадавхийг сайжруулах,
- Сангийн гадаад харилцаа, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх,
- Азийн хөгжлийн банкны төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, хэрэгжилтийг хангах зэрэг болно.

2017 онд давхардсан тоогоор нийт 104 харилцагчийн 37,800.0 сая төгрөгийн зээлд 19,100.0 сая төгрөгийн батлан даалт гаргуулах хүсэлт хүлээн авч, Зээлийн батлан даалтын хорооны хурлаар хэлэлцүүлэн 62 харилцагчид 24,900.0 сая төгрөгийн зээлд 12,300.0 сая төгрөгийн батлан даалт гаргах, мөн орон нутгийн нийт 30 харилцагчийн 6,400.0 сая төгрөгийн зээлд батлан даалт гаргуулах хүсэлт хүлээн авснаас 18 харилцагчийн 4,500.0 сая төгрөгийн зээлд 2,500.0 сая төгрөгийн батлан даалт гаргуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Зээлийн батлан даалтын сан нь тайлант онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 2017 оны 09 дүгээр сарын 29-нд Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, 2017 оны 11 дүгээр сарын 08-нд Хас банк, 12 дугаар сарын 14-нд ХААН банкт тус тус хамтран ажиллах гэрээг байгуулсан ба жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт “Эх үүсвэртэй батлан даалт”-ын бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн байна. Орон нутагт 21 салбар төлөөлөгчийн газартай хамтран ажиллах гэрээг шинэчлэн баталгаажуулан 21 төлөөлөгч, 5075 иргэнд батлан даалтын мэдээ, мэдээллийг хүргэх сургалт зохион байгуулан ажилласан байна.

Харилцагч 6 арилжааны банкнаас 18 зээлдэгчийн 1,000.0 сая төгрөгийн үүрэг гүйцэтгэлийн нэхэмжлэл ирүүлснээс 14 зээлдэгчийн 880.2 сая төгрөгийн нэхэмжлэлийг “Үүрэг гүйцэтгэх нөхцөл бүрдээгүй” шалтгаанаар буцааж, 4 зээлдэгчийн 169.1 сая төгрөгийн үүргийг гүйцэтгэсэн байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй зээлийн батлан даалтын төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2017 оны төсвийг Сангийн яамнаар батлуулсан байна. Энэхүү төслийн хүрээнд нийт 18.0 сая долларын санхүүжилтийг Азийн хөгжлийн банкаас авахаар гэрээнд тусгагдсан байгаа хэдий ч 2017 онд 6.0 сая долларын эх үүсвэрийг хүлээн авсан байна. Үлдсэн дүнг 2018 оны 1 дүгээр улиралд Сангийн яамнаас санхүүжилт хийгдэхээр чиглэл өгөгдсөн байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2017 онд Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар 12 төрлийн зөрчил илэрсэн ба үүний дагуу хэрэгжүүлэх 24 арга хэмжээний саналыг боловсруулан өгч, уг шалгалтын дүнгийн үүрэг даалгаврын биелэлтийг 2017 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор ирүүлэхийг үүрэг болгож ажилласан байна.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д Зээлийн батлан даалтын сан нь “удирдах зөвлөл, хяналтын хороо, гүйцэтгэх захирал, зээлийн батлан даалтын хороотой байна” гэж заасан бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж Сангийн гүйцэтгэх захирлаар П.Чандмань томилогдон ажиллаж байна.

Зээлийн батлан даалтын сангийн удирдлага нь Зээлийн батлан даалтын сангийн тухай, Жижиг дунд үйлдвэрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Банкны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай хуулиуд болон СТОУС, бусад холбогдох хууль эрхийн актууд, УИХ, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол, сангийн Удирдах зөвлөлийн тогтоол, Сангийн заавар, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой “Зээлийн батлан даалтын сангийн батлан даалтын үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт оруулах тухай”, “Удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн батлан даалтын хорооны гишүүний урамшууллын хэмжээ, урамшуулал олгох журам”-ыг тус тус Удирдах зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 05, 06 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлсэн байна.

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд /ТАБ-СТА-А-1/ маягтад тодорхой тусгасан.

#### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Зээлийн батлан даалтын сангийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор сангийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 31-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирлын 2016 оны А/113 дугаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт батлах тухай” тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж байгаа боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан мөрдөж буй хууль, журам, зааврын хүрээнд зохистой байдлаар бүтгэх боломж олгохгүй байна. Иймд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг үйл ажиллагааны онцлогийг тусган шинэчлэн боловсруулж мөрдөх шаардлагатай байна.



Зээлийн батлан даалтын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Зээлийн батлан даалтын сангийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Даймонд” санхүүгийн програмаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна. Санхүүгийн програмын ашиглалт хангалтгүй байна.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзэн дахин хянасан. Зээлийн батлан даалтын сангийн эрсдэлийг төлөвлөлтийн үед үр нөлөөтэй гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна.

Зээлийн батлан даалтын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтыг сангийн хяналтын зөвлөл, дотоод хяналт хариуцсан чанарын хяналтын менежер хэрэгжүүлсэн байна.

Зээлийн батлан даалтын сан нь дотоод хяналтыг хэрэгжүүлэх 2017 оны төлөвлөгөө гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна:


- Батлан даалтын хорооны шийдвэр гаргалт, батлан даалт олголт, хяналт мониторингийн үйл ажиллагаанд сангийн хяналтын зөвлөлтэй хамтран улирал бүр,
- Эрсдэл, өрийн удирдлагын хэлтсийн үйл ажиллагаа,
- Газар, хэлтсүүдийн төлөвлөгөөний биелэлт,
- Шилэн дансны мэдээлэл болон санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлбэр, үндсэн хөрөнгө, эд хөрөнгийн бүртгэл хөтлөлт, хадгалалт хамгаалалтад хагас жилээр
- Сангийн гүйцэтгэх захирлын удирдамжийн дагуу төрийн банк дахь сангийн мөнгөн хөрөнгийн дансдуудыг тулган баталгаажуулж, бүртгэлгүй мөнгөн хөрөнгө байгаа эсэхэд тус тус хяналт хийж холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт болон үйл ажиллагааны явцыг сайжруулахад зөвлөмж өгч ажилласан байна.

## 2.6 САНГИЙН ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

Удирдах зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн сангийн 2017 оны төсөв, орон тоо батлах тухай 11 дүгээр тогтоолоор сангийн үйл ажиллагааны орлого 1,558.6 сая төгрөг, үйл ажиллагааны зардал 1,202.8 сая төгрөг, нийт 34 ажилтны орон тоог батлуулан ажилласан байна.

Удирдах зөвлөлд 7, хяналтын зөвлөлд 3, захирлын зөвлөхөөр 1, орон нутгийн төлөөлөгчид 24 нийт 35 гэрээт ажилтан ажилласан.

Тайлант онд үйл ажиллагааны хүүгийн орлого 2,609.1 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн орлого 3.3 сая төгрөг, батлан даалтын хураамж, шимтгэлийн орлого 151.9 сая төгрөг нийт 2,764.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, үйл ажиллагааны зардалд 1,027.2 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 115.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.





## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Зээлийн батлан даалтын сан нь Монгол Улсын “Шилэн дансны тухай” хуулийн хүрээнд шилэн дансны мэдээллийг <https://shilendans.gov.mn/org/696> цахим хуудсаар шилэн данс гэсэн бие даасан цэстэй байна. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 6 төрлийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой 4 төрлийн мэдээлэл, бусад төрлийн 4 мэдээлэл тус тус байршуулснаас мэдээллийг сар бүр хугацаа хоцроон мэдээлсэн байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг байршуулаагүй зөрчил гаргасан ерөнхий нягтлан бодогчид сахилгын арга хэмжээ авсан байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу тохиолдох магадлалтай уламжлалт эрсдэлүүдээс 13 данс 10 уламжлалт эрсдэл, хяналтын эрсдэлүүдээс 8 данс 13 хяналтын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 31 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдэлүүдээс нөөц сангийн бүрдүүлэлт, түүний хадгаламж хэлбэрээр тусгаарлан байршуулах, санхүүгийн тайлангийн алдаатай илэрхийлэл, цалин хөлстэй холбоотой өглөг авлагын зөрчил, хүүгийн орлого, батлан даалтын хураамж, шимтгэлийн орлогын алдаатай илэрхийлэл, үйл ажиллагааны зардлын дутуу илэрхийлэл нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “бодитой оршин байх ба тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Хууль эрх зүйн орчны талаар


2017 оны жилийн эцсээрх Сангийн батлан даалт зохицуулалтын газрын мэдээгээр тайлагнасан 68 аж ахуйн нэгжийн 3,199.5 сая төгрөгийн зээлийн батлан даалт нь чанаргүй батлан даалтын үлдэгдлийн эрсдэлтэй байх үүрэг хүлээхээр тооцогдож байна.

Энэ нь Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д “Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу давхар батлан даалтын тухай журмыг батлуулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулаагүйгээс чанаргүй батлан даалтын эрсдэлийг хүлээхээр байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д заасны дагуу давхар батлан даалтын тухай журмыг баталж, мөрдүүлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах, үүнд сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг хүлээх чадварын судалгааг харилцагч банк санхүүгийн байгууллага бүрээр гарган давхар даатгалын журамд санал боловсруулж оруулах талаар албан шаардлага өгөв.

### 2.9.2 Эрсдэлийн сангийн талаар

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 238 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.10-д “банк, санхүүгийн байгууллагад мөрдөж байгаа активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмыг мөрдөж ажиллах заалтыг



зөрчиж уг журмыг боловсруулж, батлуулаагүй, эрсдэлийн сан байгуулж ажиллах эрх зүйн үндсийг бий болгоогүй байна.

Энэ нь өмнөх онуудад олгосон зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор дараагийн тайлант хугацаануудад үүсэх болзошгүй өр төлбөрийг нөхөх эх үүсвэрийг бүрдүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Журмын заалтыг хэрэгжүүлж ажиллах, Эрсдэлийн сан байгуулж ажиллах талаар албан шаардлага өгөв.

### 2.9.3 Нөөц сангийн хөрөнгийн талаар

2017 оны санхүүгийн жилд эцсийн байдлаар 50.8 сая төгрөгөөр нөөц санг дутуу байгуулсан мөн Сангийн хөрөнгийг хадгаламж хэлбэрээр банкинд тусгаарлан байршуулаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нөөц сангийн тооцоололыг хийх талаар тусгаагүй байна.

Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 238 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.9 “Сан нь батлан даалтын үүрэг гүйцэтгэх чадварыг хангах үүднээс нөөцийн сантай байх”, 2.1.11 “Нөөц санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна, Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Журмын заалтыг хэрэгжүүлж ажиллах, Нөөц сангийн бүртгэлийн талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусган ажиллах талаар албан шаардлага өгөв.

### 2.9.4 Үйл ажиллагааны зардлын төсвийн төлөвлөлтийн талаар

Үйл ажиллагааны зардлын зохистой харьцааны үзүүлэлт нь 871.2 сая төгрөг тооцогдсон байтал 1,202.8 сая төгрөг зарцуулагдахаар төсөвлөгдсөн буюу 331.6 сая төгрөгөөр илүү батлагдсан байна.

Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 238 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.7-д “үйл ажиллагааны зардлын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцохдоо үйл ажиллагааны зардлыг өөрийн хөрөнгөнд харьцуулах замаар тооцох ба зохистой харьцаа нь 15 хувиас хэтрэхгүй байх” гэж заасныг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Журмын заалтыг хэрэгжүүлж ажиллах, төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгааг үндэслэн бодитойгоор гарган төлөвлөх, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

### 2.9.5 Мөнгөн хөрөнгийн талаар

2017 онд Төрийн банкны үйл ажиллагааны дансыг төрийн банктэй цахим интернет банкны гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч, удирдлага хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэж заасныг зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

### 2.9.6 Санхүүгийн тайлагналын талаар

Аудит хийлгэхээр ирүүлсэн санхүүгийн тайланд хүүгийн орлогыг 7.0 сая төгрөгөөр илүү, батлан даалтын хураамж, шимтгэлийн орлогыг 0.7 сая төгрөгөөр дутуу, үндсэн үйл ажиллагааны зардлыг 10.5 сая төгрөгөөр дутуу тусгасан, авлага, өглөг дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад зарим ажилтанд олгосон цалингийн урьдчилгаа, ээлжийн амралтын цалинг урьдчилан олгохдоо харилцагчаар нэр үүсгэж бүртгээгүйгээс санхүү байдлын тайланд цалингийн авлага 1.2 сая төгрөг, өглөг 3.8 сая төгрөгөөр хооронд хаах бичилт хийсэн зэрэг алдаатай илэрхийлэгдсэн.

Дээрхи алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

### 2.9.7 Биет бус хөрөнгийн талаар

2017 оны 12 дугаар сарын 21-нд ГрэйпСити Монгол ХХК-тай MARS-CGF төслийн програм хангамж нийлүүлэх гэрээ байгуулан гэрээний урьдчилгаа болох 17.7 сая төгрөгийг шилжүүлж, биет бус хөрөнгийг 17.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь НББОУС (16.7) а. Аж ахуйн нэгж нь ирээдүйд тухайн хөрөнгөөс эдийн засгийн үр өгөөж хүртэх магадлалтай байх; ба б. Хөрөнгийн өртөгийг найдвартай хэмжих боломжтой байх гэсэн стандартыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэж санхүүгийн тайланг залруулсан.

### 2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. 2016 оны 6 дугаар сарын 22-нд “Чингис хааны хүрээ” ХХК-д БДГ-12/1639 дугаар бүхий Төрийн банкттай байгуулсан батлан даалтын гэрээгээр 2,499.9 сая төгрөгийн батлан даалт гаргасан байдаг. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хяналт тавих журам”-ыг батлах тухай 344 дүгээр тогтоолыг мөрдөж байсан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Хорооны 2012 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан журамд нэмэлт оруулах тухай” 232 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд 2.1.6<sup>1</sup> “Сан нь улс орны онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ журмын 2.1.6 дахь заалтад заасан өөрийн хөрөнгийн 10 хувиас дээш хэмжээгээр нэг зээлдэгч / жижиг, дунд үйлдвэр эрхлэгч/-д батлан даалт гаргах нөхцөлд Сангийн удирдах зөвлөлийн тогтоолыг үндэслэн Хорооны дарга зөвшөөрөл олгож болно” гэсэн нэмэлт заалт оруулснаар дээрх гэрээний батлан даалт хэрэгжсэн байна.



“Чингис хааны хүрээ” ХХК-д гаргасан 2,499.9 сая төгрөгийн батлан даалт нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Сангийн хөрөнгийн 31.3 хувийг эзэлж байгаа нь эрсдэл авчирч болзошгүй байна.

2. Тайлант онд өмнөх оноос 4 зээлдэгчийн батлан даалтын үүрэг гүйцэтгэлтэй холбоотойгоор хувь хүнээс авах авлага 169,1 сая төгрөгөөр, нөөц санд буцаан төвлөрүүлэхээр өглөг 169,1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Иймээс чанаргүй зээлийн эргэн төлөлтөнд анхаарал хандуулах шаардлагатай байна.

### 2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Тус сангийн 2017 оны нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлагнах үйл ажиллагаа нь СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврыг зөрчөөгүй үнэн зөв илэрхийлэгдсэн боловч сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль дүрэм журмуудын хоорондын нийцэл, хэрэгжилтийг хянан зөвлөмж, дүгнэлт гаргах шаардлагатай байна.

### 2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Зээлийн батлан даалтын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 259.3 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс аудитын асуудлын бүртгэлд тэмдэглэгдсэн 2 алдааг хүлээн зөвшөөрч 90.2 сая төгрөгийг аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан, 5 зөрчилд 3 албан шаардлага, 2 зөвлөмж өгөв.


### 2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Зээлийн батлан даалтын сангийн 2016 оны санхүүгийн тайланд “Ди Эй Би Жи Аудит” ХХК аудит хийж өмнөх оны аудитаар төлбөрийн акт, албан шаардлага тавигдаагүй бөгөөд Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 11.2-д “Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс чанаргүй батлан даалтын үүрэг хүлээх эрсдэлтэй, батлан даалт гаргасан зээлдэгчийн үйл ажиллагааны салбараар нь ангилж үзэхэд боловсрол, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуй зэрэг салбарууд байгаа нь Зээлийн батлан даалтын сангийн хуулийн 9.1.1-д “Банк санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах” гэсэн заалтыг зөрчсөн гэсэн үндэслэлээр хязгаарлалттай санал дүгнэлт, эрсдлийн сангийн хөрөнгө, төсвийн гүйцэтгэл, хүүгийн орлогын авлага зэрэг асуудалд нийт 3 зөвлөмж өгсөн байна. 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь, 1 зөвлөмжийн биелэлт (Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах) гэсэн заалт хангалтгүй байна гэж үзлээ.

### 2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 23,291.1 сая төгрөгөөс 1 хувиар тооцож 232.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



## **2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Зээлийн батлан даалтын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

---

Аудитын ажил гүйцэтгэх гэрээгээр Номгон аудит ХХК-ийн илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захиралд зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал, дүгнэлт гаргахад зориулагдсан. Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Бидний энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Зээлийн батлан даалтын сангийн удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



**3.1 Үйл ажиллагааны зардлын төсвийн  
төлөвлөлтийн талаар****Тэргүүлэх ач холбогдол №4****Ажиглалт**

Үйл ажиллагааны зардлын зохистой харьцааны үзүүлэлт нь 871.2 сая төгрөг тооцогдсон байтал 1,202.8 сая төгрөг зарцуулагдахаар төсөвлөгдсөн буюу 331.6 сая төгрөгөөр илүү батлагдсан байна.

Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 238 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.7-д “үйл ажиллагааны зардлын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцохдоо үйл ажиллагааны зардлыг өөрийн хөрөнгөнд харьцуулах замаар тооцох ба зохистой харьцаа нь 15 хувиас хэтрэхгүй байх” гэж заасныг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй байна.

**Зөвлөмж**

Журмын заалтыг хэрэгжүүлж ажиллах, төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгааг үндэслэн бодитойгоор гарган төлөвлөх, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 01-ний дотор санхүүгийн аудитын газар ирүүлнэ үү

**Эрсдэл**

1. Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх
2. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Цаашид зөвлөмжийн хэрэгжилтийг хүлээн авч хэрэгжүүлнэ.





**3.2 Мөнгөн хөрөнгийн талаар****Тэргүүлэх ач холбогдол №5****Ажиглалт**

2017 онд Төрийн банкны үйл ажиллагааны дансыг төрийн банктай цахим интернет банкны гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч, удирдлага хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэж заасныг зөрчсөн байна.

**Зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 01-ний дотор санхүүгийн аудитын газар ирүүлнэ үү.

**Эрсдэл**

1. Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх
2. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Цаашид зөвлөмжийг хүлээн авч мөрдөж ажиллана.




#### 4 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6,213,932,552.38	22,646,050,422.56
1.1.2	Богино хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.1.3	Авлага	180,722,842.49	399,314,858.22
1.1.4	Найдваргүй авлагын хасагдуулга	0.00	0.00
1.1.5	Бараа материал	6,505,629.00	16,987,974.00
1.1.6	Урьдчилж төлсөн зардал тооцоо	5,275,000.00	23,025,000.00
1.1.9	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,406,436,023.87</b>	<b>23,085,378,254.78</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	194,741,479.90	303,238,479.90
1.2.2	Хуримтлагдсан элэгдэл -ҮХ	-118,580,262.45	-148,040,151.71
1.2.3	Бусад үндсэн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Хуримтлагдсан элэгдэл-БҮХ	0.00	0.00
1.2.5	Биет бус хөрөнгө	77,712,000.00	74,737,900.00
1.2.6	Хуримтлагдсан элэгдэл-ББХ	-25,771,444.41	-24,196,647.81
1.2.9	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>128,101,773.04</b>	<b>205,739,580.38</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,534,537,796.91</b>	<b>23,291,117,835.16</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	0.00	169,170,177.80
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	7,378,374.00
2.1.1.3	Татвар, хураамжийн өглөг	0.00	1,993,577.00
2.1.1.4	Банкны богино хугацаат зээлийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Бусад өглөг	0.00	66,906,486.32
2.1.1.8	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.00</b>	<b>245,448,615.12</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	15,323,771,555.98
2.1.2.2	Бусад урт хугацаат өр төлбөр	160,000,000.00	280,000,000.00
2.1.2.3	...	0.00	0.00



2.1.2.4	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>160,000,000.00</b>	<b>15,603,771,555.98</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>160,000,000.00</b>	<b>15,849,220,171.10</b>
2.3	Цэвэр хөрөнгө	0.00	0.00
2.3.1	Нөөц: а) хязгаарлалтгүй	0.00	0.00
2.3.2	б) хязгаарлалттай	5,040,000,000.00	5,040,000,000.00
2.3.3	Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00
2.3.4	Цэвэр хөрөнгийн бусад хэсэг	768,400,000.00	1,249,299,822.20
2.3.5	Хуримтлагдсан үр дүн	566,137,796.91	1,152,597,841.86
2.3.6	<b>Цэвэр хөрөнгийн дүн</b>	<b>6,374,537,796.91</b>	<b>7,441,897,664.06</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,534,537,796.91</b>	<b>23,291,117,835.16</b>



**4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>		
1.1	Гишүүдийн татвар /хүүгийн орлого/	942,605,833.07	2,609,089,448.76
1.2	Хөтөлбөр, төслийн орлого	3,990,000.00	3,335,000.00
1.3	Бэлэг, хандив, тусламжийн орлого	0.00	0.00
1.4	Батлан даалтын шимтгэл, хураамжийн орлого	218,877,236.00	0.00
1.5	Хөрөнгө оруулалтын орлого	0.00	0.00
1.6	Бусад орлого /Батлан даалтын хураамж, шимтгэлийн орлого/	0.00	151,988,165.00
<b>1.7</b>	<b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>1,165,473,069.07</b>	<b>2,764,412,613.76</b>
<b>2</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>		<b>469,813,290.97</b>
2.1	Бэлэг, хандив ба тусламж	0.00	0.00
2.2	Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	0.00	467,651,555.98
2.3	Төсөл хэрэгжүүлсний зардал	3,990,000.00	2,161,734.99
<b>2.4</b>	<b>Ерөнхий ба удирдлагын зардал</b>	<b>861,627,541.76</b>	<b>1,062,803,140.41</b>
2.4.1	Цалин хөлс, шагнал	489,295,508.76	593,501,203.00
2.4.2	Нийгмийн даатгалын шимтгэл	54,312,768.06	66,516,002.00
2.4.3	Засвар үйлчилгээний зардал	2,447,250.00	20,950,140.00
2.4.4	Ашиглалтын зардал	0.00	0.00
2.4.5	Түрээсийн зардал	151,726,162.00	119,916,000.00
2.4.6	Албан томилолтын зардал	33,771,095.45	51,969,404.80
2.4.7	Тээвэр, шатахууны зардал	13,108,522.27	15,198,080.00
2.4.8	Элэгдлийн зардал	39,716,512.92	37,896,992.66
2.4.9	Зар сурталчилгааны зардал	14,855,063.20	49,963,172.00
2.4.10	Шуудан, холбооны зардал	7,200,657.31	7,705,420.65
2.4.11	Татварт төлсөн	0.00	15,465,038.50
2.4.12	Найдваргүй авлагын зардал	0.00	0.00
2.4.13	Шагнал, урамшууллын зардал	28,167,000.00	32,305,350.00
2.4.14	Зээлийн хүүгийн зардал	0.00	0.00
2.4.15	Бусад зардал	27,027,001.79	51,416,336.80
<b>2.5</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн</b>	<b>865,617,541.76</b>	<b>1,532,616,431.38</b>
<b>2.6</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны үр дүн</b>	<b>299,855,527.31</b>	<b>1,231,796,182.38</b>

3	<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал</b>	<b>328,484.75</b>	<b>301,849.00</b>
3.1	Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг (алдагдал)	0.00	0.00
3.2	Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал)	0.00	301,849.00
3.4	Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг (алдагдал)	0.00	0.00
3.5	Татварын зардал	0.00	0.00
3.6	Бусад	328,484.75	0.00
4	<b>Онцгой шинжтэй зүйлс-цэвэр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
5	<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ҮР ДҮН</b>	<b>300,184,012.06</b>	<b>1,232,098,031.38</b>




**4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
<b>1</b>	<b>2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>5,040,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>568,383,765.00</b>	<b>465,970,019.85</b>	<b>6,374,537,796.91</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	5,040,000,000.00	0.00	0.00	0.00	0.00	568,383,765.00	465,970,019.85	6,074,353,784.85
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	200,016,235.00	-200,016,235.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>7</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>300,184,012.06</b>	<b>300,184,012.06</b>
<b>1</b>	<b>2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>5,040,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>768,400,000.00</b>	<b>566,137,796.91</b>	<b>6,374,537,796.91</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	5,040,000,000.00	0.00	0.00	0.00	0.00	768,400,000.00	566,137,796.91	6,374,537,796.91
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	480,899,822.20	-645,637,986.40	-164,738,164.23
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>7</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>1,232,098,031.38</b>	<b>-1,232,098,031.38</b>



8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	<b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>5,040,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>1,249,299,822.20</b>	<b>1,152,597,841.86</b>	<b>7,441,897,664.06</b>






**4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Үйл ажиллагааны мөнгөн орлого (+)</b>	<b>349,557,333.57</b>	<b>712,334,268.43</b>
1.1.1	(а) Гишүүдийн татвараас орсон мөнгө	0.00	0.00
1.1.2	(б) Төсөл, хөтөлбөрөөс хүлээн авсан мөнгө	3,860,000.00	0.00
1.1.3	(в) Бэлэг, хандив, тусламж	0.00	0.00
1.1.4	(г) Түрээсийн орлогод хүлээн авсан мөнгө	0.00	30,390,000.00
1.1.5	(д) Бусад	345,697,333.57	681,944,268.43
<b>1.2</b>	<b>Үйл ажиллагааны мөнгөн зарлага (-)</b>	<b>868,535,203.58</b>	<b>1,279,350,736.24</b>
1.2.1	(а) Ажилагчдад олгосон мөнгө	425,267,364.69	482,237,413.21
1.2.2	(б) Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	100,866,891.56	121,327,072.01
1.2.3	(в) Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	18,138,340.00	61,529,702.00
1.2.4	(г) Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	156,283,585.31	119,916,000.00
1.2.5	(д) Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	11,609,200.00	3,795,045.00
1.2.6	(е) Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	113,338,891.27	43,493,972.00
1.2.7	(ё) Төлсөн хүү	0.00	0.00
1.2.8	(ж) Төлсөн татвар	43,030,930.75	65,861,959.43
1.2.9	(з) Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	0.00	2,032,200.00
1.2.10	(и) Бусад	0.00	379,157,372.59
<b>1.3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-518,977,870.01</b>	<b>-567,016,467.81</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого	2,000,000,000.00	0.00
2.2	Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	-1,371,500.00	-115,534,800.00
2.3	Худалдсан хөрөнгө оруулалтын орлого	0.00	0.00
2.4	Худалдаж авсан хөрөнгө оруулалт	0.00	0.00
2.5	Бусад	0.00	120,000,000.00
<b>2.6</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,998,628,500.00</b>	<b>4,465,200.00</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Банкнаас авсан зээл	0.00	14,837,120,000.00



3.2	Санхүүгийн түрээсийн өглөгийн төлбөр	0.00	0.00
3.3	Зээлийн төлөлт	0.00	0.00
3.4	Улсаас өгсөн санхүүжилт	0.00	0.00
3.5	Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт	0.00	0.00
3.6	Хүү ба урамшууллын орлого	810,736,157.94	2,307,649,315.79
3.7	Валютын ханшны зөрүү	0.00	0.00
3.8	Бусад	0.00	-169,100,177.80
<b>3.9</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>810,736,157.94</b>	<b>16,994,669,137.99</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>2,290,386,787.93</b>	<b>16,432,117,870.18</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,923,545,764.45</b>	<b>6,213,932,552.38</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,213,932,552.38</b>	<b>22,646,050,422.56</b>

